



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 411

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Баянчандмань АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1.“Баянчандмань АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Нямхүүгийн Одхүүг өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг 2020 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөр тасалбар болгон холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцлах;

1.2.“Баянчандмань АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлыг томилогдтол захирлын албан үүргийг ерөнхий инженер Буянжаргалын Мөнхбаяраар түр хавсран гүйцэтгүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

000705